

МОНГОЛ УЛСЫН ЭРЧИМ ХҮЧНИЙ САЛБАРЫН ТАЛААРХ ОЛОН НИЙТИЙН ҮЗЭЛ БОДОЛ

*Б.Мөнхжаргал, Эдийн засгийн ухааны магистр, Олон улс судлалын магистр.
Ахлах багш, Хүн Амын Сургалт, Судалгааны Төв,
Эдийн Засгийн Сургууль, Монгол Улсын Их Сургууль*

Хураангуй

Монгол улсад 20 гаруй жилийн өмнөөс эдийн засгийн гол салбарууд хувьд шилжин зах зээлийн зарчмаар ажиллах болсон ч улс орны хөгжилд томоохон үүрэгтэй эрчим хүчний салбар өнөөг хүртэл төрийн мэдэлд, татаастай үнээр, санхүүгийн алдагдалтай, ачааллаа дийлэхгүй ажиллаж, шаардлагатай хөрөнгө оруулалтаар дутмаг явж байна. Төрөөс эрчим хүчний салбарыг шинэчлэх, үнэ тарифыг чөлөөлөх ажлыг эхлүүлэн хэрэгжүүлж байгаа бөгөөд олон нийт энэ салбарын талаар ямар ойлголт, мэдлэг, мэдээлэлтэй байгаа, шинэчлэл, ялангуяа эрчим хүчний үнэ тарифийн чөлөөлөлтөд хэр “бэлэн” байгааг тодорхойлох явдал судалгааны зорилго байв.

Судалгаанд Улаанбаатар хотын байшин, гэр хороололд амьдарч буй 410 өрх хамрагдсан. Хотын өрхүүд бараг бүгдээрээ эрчим хүчний үйлдвэрлэлийн талаар ерөнхий мэдлэгтэй байгаа боловч салбарын одоогийн санхүүгийн нөхцөл байдал хүндрэлтэй байгаа талаар дөнгөж 26-28 хувь нь л мэдэж байна. Өрхүүдийн дийлэнх өнгөрсөн хоёр жилийн хугацаанд цахилгааны тариф байнга нэмэгдэж ирснийг анзаарсан бөгөөд энэ нь өрхүүдийн амьжиргаанд нэлээд нөлөө үзүүлсэн байна. Ижил төстэй хөгжилтэй Азийн улс орнуудтай харьцуулахад Монголд нэгж цахилгааны тариф тийм өндөр биш ч өрхүүдийн гуравны хоёр нь одоогийн цахилгааны үнэ тарифийг өндөр гэж үзэж байгаа ба цаашид өснө гэсэн таамаглалтай байна. Гэхдээ үүний шалтгааныг цалин болон үнийн өсөлт, инфляцитай холбоотой гэж тэд үзэж байна. Эрчим хүчний эрэлт нь мэдрэмж муутай, өөрөөр хэлбэл тариф өссөн ч эрчим хүчний хэрэглээ ихээр буурдаггүй учраас цахилгааны үнэ нэмэгдсэн тохиолдолд цахилгааны хэрэглээгээ хэвээр байлгана гэвэл нэн ядуу өрхүүдийн хувьд хоол хүнс, эрүүл мэнд, боловсрол гэх мэт зайлшгүй хэрэгцээнүүдэд нь дарамт учрахаар, харин орлого дээгүүр өрхүүдийн хувьд цахилгаан юмуу зайлшгүй хэрэгцээнээс бусад гар утас, автомашин гэх мэт зүйлд зарцуулах зардлын хооронд сонголт хийх хандлага гарч болзошгүй байна.

ТҮЛХҮҮР ҮГС: эрчим хүчний хэрэглээ, цахилгааны үнэ

СУДАЛГААНЫ ҮНДЭСЛЭЛ

Монгол улсын эрчим хүчний салбар нь 1920-оод оноос үндэс сууриа тавьж, 1960-1990-ээд онуудад “өрнүүн хөгжсөн” гэж түүхнээ тэмдэглэгдсэн байдаг. Зах зээлийн эдийн засгийн системд шилжиж эхэлсэн 1990-ээд оны эхэн үед үйлдвэрлэлийн уналтаас болж эрчим хүчний хэрэглээ огцом буурснаас гадна хуучнаар ЗХУ-ын дэмжлэг зогсож эрчим хүчний үйлдвэрүүдийн тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээ тасарч, санхүүгийн чадавхи доройтон, цахилгаан дулааны үйлдвэрлэх, дамжуулах, түгээх сүлжээний тоног төхөөрөмжүүд ашиглалтын шаардлага хангахгүй болж, салбар ерөнхийдөө аварийн байдалд орсон байна.

1990-ээд дунд үеэс гуравдагч орон болон олон улсын санхүүгийн байгууллагуудын тусламж дэмжлэгээр уг салбар эргэн сэргэж хэрэглэгчдээ цахилгаан, дулаанаар хангаж чадах болсон² боловч сүүлийн жилүүдэд эрчим хүчний үйлдвэрүүдийн тоног төхөөрөмж хуучирч, ашиглалтын шаардлага хангахгүй болж байгаагаас зарим томоохон аваарь саатал гарах, цахилгаан дулааны хангамжийг их бага хугацаагаар тасалдуулах тохиолдол нэмэгдэж байна. Түүнээс гадна төр засгаас цахилгаан дулааны үнэ тарифийг удаан хугацаанд барьж ирсэн нь эрчим хүчний компаниудын санхүүгийн байдлыг сулруулаад байна. Төрөөс тогтоосон цахилгаан, дулааны үнэ тариф нь үйлдвэрлэл, үйлчилгээний урт хугацааны зардлыг нөхөж чадахгүй

² <http://www.mmre.energy.mn/branch/history>

байгаагаас эрчим хүчний компаниуд төрийн татаасаас хараат болох байдал нэмэгдэж, эрчим хүчний үйлдвэр, уурхай, бэлтгэн нийлүүлэгч, хэрэглэгчийн хооронд их хэмжээний өр, авлага үүсээд байна. Эрчим хүчний татаас бүхий доогуур үнэ нь нэг талаар нийгмийн сайн сайхныг дэмжиж байна гэж үзэгддэг ч нөгөө талаараа эрчим хүчний салбарын хөгжлийг удаашруулж, хувийн хэвшлийнхний салбарт хөрөнгө оруулах сонирхлыг үгүй хийж байна гэж салбарынхан хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлэх болжээ.

1990-ээд оны эхэн үеэс эрчим хүчний салбарын эрх зүй, бодлогын хүрээнд зарим ахиц гарч гол хэрэгцээтэй хуулиуд баглагдан, салбарын ирээдүйн хөгжлийн хандлагыг тодорхойлох бодлогын баримт бичгүүдийг боловсруулсан ч тэдгээрийн практик хэрэгжилт улс төрийн болон бусад шалтгаанаар хангалтгүй, өнөөдрийг хүртэл зах зээлийн зарчмыг нэвтрүүлээгүй байна. Мөн удаан хугацааны туршид эрчим хүчийг татаас бүхий хямд үнээр авч хэрэглэж байснаас олон нийтийн эрчим хүчний зохистой хэрэглээний мэдлэг, практик хангалтгүй байгаа нь салбарын шинэчлэлийг эрүүл саруул өнцгөөс ойлгож, хүлээн авах хандлагад нь сөргөөр нөлөөлж болох юм. Олон дахин, удаан хугацаагаар тасрах болсон цахилгааны тасалдлыг үл тооцвол, Монголын эрчим хүчний системд нүүрлээд байгаа илүү том аюулыг олон нийт бүрэн ухаарч мэдрээгүй байна.

Судалгааны зорилго

Энэхүү судалгааны гол зорилго нь Монголын эрчим хүчний салбарын өнөөгийн байдал, салбарт тулгамдаж буй асуудлууд, системийн хэвийн байдал болон найдвартай үйл ажиллагааг хангахтай холбоотой хийгдэх шаардлагатай зүйлсийн талаар олон нийтийн ойлголт, мэдлэг, хандлага болон мэдээлэл ямар байгааг судлах явдал байв.

СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

Судалгаанд тоон судалгааны арга болон хоёрдогч тоо мэдээлэл, баримт судлалын аргуудыг ашигласан. Судалгааны үндсэн нэгж нь Улаанбаатар хотын гэр ба байшин хороололд амьдарч буй өрхүүд юм.

Судалгааны түүвэрлэлт ба хамрагдалт

Өрхийн түүвэрлэлтийг хийхдээ 2009 оны эцсийн байдлаарх Улаанбаатар хотын дүүрэг, хороодын өрх, хүн амын мэдээллийг суурь болгон олон шатат түүвэрлэлтийн аргыг ашигласан. Түүврийн нэгж болох өрхийг сонгохдоо “*өрх, хүн амын бүртгэлийн жагсаалт*”-ыг түүврийн хүрээ болгов.

Судалгаанд Хан-Уул, Сүхбаатар, Сонгинохайрхан дүүргүүдээс 6 гэр хорооллын, 6 байшин хорооллын, нийтдээ 12 хорооны 410 өрх³ хамрагдав (Хүснэгт 1). Тэдгээр 12 хороо нь дүүрэг тус бүрийн төвийн болон захын хорооллын өрхүүдийг төлөөлж байгаа болно.

Хүснэгт 1: Судалгааны түүврийн хэмжээ, хамрагдалт

Дүүрэг	Судалгаанд сонгогдсон өрхийн тоо	Өрхийн хамралтын хувь
Хан-Уул	136	100.0
Сүхбаатар	136	100.0
Сонгинохайрхан	138	100.0
Нийт	410	100.0

Судалгааны хязгаарлагдмал байдал

Судалгааг Бреактрү байгууллагын захиалгаар гүйцэтгэсэн бөгөөд цаг хугацаа, санхүүгийн хязгаарлагдмал байдалтай холбоотойгоор зөвхөн Улаанбаатар хотын өрхүүдийг хамруулсан. Иймд, тэдний үзэл бодол нь амьжиргаа, эдийн засгийн байдлаараа багагүй ялгаатай хөдөө, орон нутгийн өрхүүдийн үзэл бодлыг бүрэн төлөөлж чадахгүй.

ЭРЧИМ ХҮЧНИЙ САЛБАРЫН ТАЛААРХ ОЛОН НИЙТИЙН ҮЗЭЛ БОДОЛ

Судалгаанд оролцсон өрх, хүн амын шинж байдал

Судалгаанд хамрагдсан өрхүүдийн 50 хувь нь орон сууцанд, 28 хувь нь гэрт, 22 хувь нь хашаа, байшинд амьдардаг өрхүүд байв. Өрхүүдийн хүн ам зүйн шинж байдлыг нарийвчлан авч үзвэл (Хүснэгт 2),

³ УБ-ын нийт өрхийн 0.15 хувь

судалгаанд хамрагдсан 410 өрхөд нийт 1795 хүн амьдарч байгаа ба тэдний 910 нь гэр хороололд, 885 нь байшин хороололд байна.

Судалгаанд хамрагдсан өрхүүдийн тал хувь нь 4 хүртэл тооны гишүүнтэй, үлдсэн тал хувь нь 4-өөс олон тооны гишүүнтэй байгааг өрхөд амьдардаг хүний голч тооны үзүүлэлт харуулж байна. Өрхийн байршлаар нь харвал, цөөн (1-3) ам бүлтэй өрх байшин хороолол (31,2%)-д гэр хороолол (29,8%)-оос олон, харин олон ам бүлтэй өрх гэр хороолол (21%)-д байшин хороолол (20%)-оос олон байлаа.

Өрхөд хөдөлмөрийн бус насны хүмүүс (0-15 насны хүүхэд, тэтгэврийн насны хүмүүс) олон, харин хөдөлмөрийн насны хүмүүсийн тоо цөөн байх тусам тухайн өрх эрчим хүчний тарифийн өөрчлөлтөд илүү мэдрэмтгий байх магадлалтай. Тэгвэл судалгаанд хамрагдсан өрхүүдийн хувьд 1 өрхөд ногдох хүүхдийн дундаж тоо 1,1, тэтгэврийн насны хүмүүсийн дундаж тоо 0,4 байгаа ба гэр хорооллын өрхүүд байшин хорооллынхныг бодоход арай олон хүүхэдтэй, арай цөөн тэтгэврийн насны хүмүүстэй байна.

Хүснэгт 2: Судалгаанд хамрагдсан өрхүүдийн хувийн жин, өрхийн хүн ам зүйн шинж байдал, байршлаар

Өрхийн хүн ам зүйн шинж байдал	Өрхийн байршил		Нийт
	Гэр хороолол	Байшин хороолол	
Өрхөд амьдардаг хүний тоо			
1-3	29.8	31.2	30.5
4-5	49.2	48.8	49.0
6+	21.0	20.0	20.5
<i>1 өрхөд амьдардаг хүний дундаж тоо</i>	<i>4.4</i>	<i>4.3</i>	<i>4.4</i>
<i>1 өрхөд амьдардаг хүний голч тоо</i>	<i>4.0</i>	<i>4.0</i>	<i>4.0</i>
<i>Өрхүүдэд амьдарч буй хүмүүсийн нийт тоо</i>	<i>910</i>	<i>885</i>	<i>1795</i>
Өрхөд амьдардаг 0-15 насны хүүхдийн тоо			
0	28.3	39.0	33.7
1	36.1	32.2	34.1
2	24.4	20.0	22.2
3 буюу түүнээс олон	11.2	8.8	10.0
<i>1 өрх дэх хүүхдийн дундаж тоо</i>	<i>1.2</i>	<i>1.0</i>	<i>1.1</i>
Өрхөд амьдардаг 60+ насны хүний тоо			
0	76.1	66.8	71.4
1	15.6	23.9	19.8
2	8.3	9.3	8.8
<i>1 өрх дэх тэтгэврийн насны хүний дундаж тоо</i>	<i>0.3</i>	<i>0.4</i>	<i>0.4</i>
Сууцанд амьдардаг гэр бүлийн тоо			
1	77.1	73.2	75.1
2	20.5	22.9	21.7
3-4	2.4	3.9	3.2
<i>1 сууцанд амьдардаг гэр бүлийн дундаж тоо</i>	<i>1.2</i>	<i>1.3</i>	<i>1.3</i>
Бүгд	100.0	100.0	100.0
Судалгаанд хамрагдсан өрхийн тоо	205	205	410

Өрхийн амьдралын нөхцөл хэр тав тухтай байгааг илэрхийлж болох нэг үзүүлэлт нь нэг сууцанд хэдэн гэр бүл амьдарч байгаа талаарх үзүүлэлт юм. Энэ үзүүлэлт нөгөө талаар өрхийн орлогод

нөлөөлж болно. Тухайлбал, олон гэр бүлээрээ нэг сууцанд амьдардаг өрхүүдэд орлого ологчдын тоо олон байх магадлалтай учраас өрхийн нийт орлого өндөр байж болох юм. Судалгаанд хамрагдсан

өрхүүдийн хувьд байшин, гэр хороололд онцын ялгаагүйгээр сууцандаа дангаараа амьдардаг гэр бүлүүд зонхилж (дөрөвний гурав) байна.

Судалгаанд хамрагдсан өрхүүдийн амьжиргааны байдлыг илэрхийлэх үзүүлэлтүүдийг Хүснэгт 3-т харуулав. Өрхүүдийн мэдээлэлд үндэслэн тооцоолсноор, нэг өрхийн сарын дундаж нийт орлого 573786,83 төгрөг байгаа ба

үүнийг өрхийн нэг хүнд ногдох байдлаар харвал, дунджаар өрхийн нэг гишүүнд сард 141388,30 төгрөг ногдож байна. Өрхийн байршлаар ялган харвал, байшин хорооллын өрхүүдийн сарын дундаж нийт орлого 714265,85 төгрөг байгаа нь гэр хороололд амьдардаг өрхийнхөөс 65 хувиар өндөр, нэг хүнд ногдох орлого 178523,31 төгрөг байгаа нь гэр хорооллынхны орлогоос 70 хувиар өндөр байна.

Хүснэгт 3: Судалгаанд хамрагдсан өрхүүдийн хувийн жин, өрхийн амьжиргааны үзүүлэлт, байршлаар

Өрхийн амьжиргааны үзүүлэлтүүд	Өрхийн байршил		Нийт
	Гэр хороолол	Байшин хороолол	
Өрхийн сарын нийт орлого			
340 000 төгрөг буюу түүнээс бага	42.0	26.2	34.1
340 001-620 000 төгрөг	39.5	26.8	33.2
620 001 төгрөг буюу түүнээс дээш	18.5	46.8	32.7
<i>Нэг өрхийн сарын дундаж нийт орлого (төг)</i>	<i>433,307.80</i>	<i>714,265.85</i>	<i>573,786.83</i>
<i>Өрхийн 1 х.н сарын дундаж нийт орлого (төг)</i>	<i>104,253.30</i>	<i>178,523.31</i>	<i>141,388.30</i>
Амьжиргааны түвшин*			
Ядуу	56.6	29.8	43.2
Үүнээс, нэн ядуу	(29.3)	(7.8)	(18.5)
Ядуу бус	43.4	70.2	56.8
Бүгд	100.0	100.0	100.0
Судалгаанд хамрагдсан өрхийн тоо	205	205	410

Тэмдэглэгээ: * УСХ-оос гаргасан аргачлалын дагуу өрхийн нэг хүнд ногдох сарын орлого нь 2010 оны Улаанбаатар хотын хүн амын амьжиргааны доод түвшин болох 101600 төгрөг хүрэхгүй байгаа өрхийг ядуу өрх, харин өрхийн 1 х.н орлого нь амьжиргааны доод түвшингийн 60 хувьд хүрэхгүй байгаа өрхийг нэн ядуу өрх гэж үзсэн.

Гэр ба байшин хорооллын өрхүүдийн нэг хүнд ногдох сарын орлогын дундаж үзүүлэлтүүд (104253,30 төгрөг, 178523,31 төгрөг) 2010 оны Улаанбаатар хотын хүн амын амьжиргааны доод түвшин болох 101600 төгрөгөөс дээш байгаа мэт боловч, тэдгээр нь нийт 410 өрхийн хувьд дундажлагдан тооцогдсон үзүүлэлт учраас өрхүүдийн амьжиргааны ялгаатай байдлыг харуулж чадахгүй. Иймд, өрх тус бүрийн нэг хүнд ногдох сарын орлогын үзүүлэлтийг тооцож, түүнийг сарын амьжиргааны доод түвшин болох 101600 төгрөгөөс дээш, доош байгаагаар ялган харвал, судалгаанд хамрагдсан нийт өрхийн 43,2 хувь нь ядуу (үүний 18,5 хувь нэн ядуу), 56,8 хувь нь ядуу бус гэсэн ангилалд орж байна. Байршлаар ялган харвал, ядуу өрхүүд гэр хороололд 56,6 хувь (үүний 29,3 хувь нь нэн ядуу) байгаа нь байшин

хорооллын ижил үзүүлэлтээс бараг 2 дахин өндөр байна. Ийнхүү гэр хорооллын өрхүүдийн амьжиргааны түвшин илүү дорой байгаагаас дүгнэхэд эрчим хүчний үнэ тарифт гарах өсөлт нь эдгээр өрхүүдэд харьцангуй хүнд тусахаар байна. Учир нь ядуу өрхүүд төсөвтөө багтдаг бараа үйлчилгээний тарифын өөрчлөлтөд эмзэг байдаг.

Өрхүүдийн орлогын бүтцийг авч үзэхэд, цалин (57,6%), хувийн бизнес (17,1%), тэтгэвэр (12,7%) зэрэг нь орлогын хамгийн том эх үүсвэрүүд болж байгаа ба нийгмийн халамж, тэтгэмжүүдээс авдаг орлого өрхийн орлогын 9,5 хувийг, хамаатан садны тусламж, түрээс/хүүгийн орлого, мал аж ахуй, хүнсний ногоо тариалах зэрэг бусад эх үүсвэрүүдээс олдог орлого 3,1 хувийг бүрдүүлдэг байна.

Судалгаанд хамрагдсан өрхүүдийн цахилгаан эрчим хүчний хэрэглээ

Судалгаанд хамрагдсан өрхүүдийн цахилгааны хэрэглээний үзүүлэлтийг Хүснэгт 4-т харуулав. Нийт өрхүүдийн 99,3 хувь нь цахилгаанд холбогдсон, харин 0,7 хувь нь цахилгааны шугамгүй, айл буух зөвшөөрөлгүй газруудад буусан, төлбөрийн чадваргүй гэх мэт шалтгаанаар цахилгаан эрчим хүчинд холбогдож чадаагүй гэр хорооллын өрхүүд байв. Хэдийгээр судалгаанд хамрагдсан өрхүүдийн дийлэнх цахилгаанд холбогдсон байсан ч хотын төвөөс алслагдсан гэр хорооллуудаас судалгаанд хамрагдсан өрхүүдийн дунд өөрийн гэсэн цахилгаан хэрэглэгчийн гэрээгүй, хажуугийн буюу ойрын цахилгаанд холбогдсон айлуудаасаа цахилгаан салаалан хэрэглэж, тухайн айлдаа цахилгааны мөнгө төлдөг өрхүүд нэлээд хэд байсныг дурьдах нь зүйтэй.

Энэхүү судалгаанд өрхүүдийн цахилгааны хэрэглээг цахилгааны төлбөрт сард төлдөг мөнгөөр нь хэмжсэн. Сард дунджаар 13167 хүртэл төгрөг буюу 150 квтц хүртэлх цахилгаан хэрэглэдэг айл нийт өрхүүдийн 36,3 хувийг, 13168-21945 төгрөгийн буюу 151-250 квтц цахилгаан хэрэглэдэг айл 40,5 хувийг, харин 21945-аас дээш төгрөгийн буюу 250-аас дээш квтц цахилгаан⁴ хэрэглэдэг айл 22,5 хувийг эзэлж байна. Дунджаар, судалгаанд хамрагдсан 1 өрх сардаа 16387,85 төгрөгийн буюу 186,7 кВтц-ийн цахилгаан хэрэглэдэг гэсэн тооцоо гарлаа. Үүнийг өрхийн нэг хүнд ногдох байдлаар харвал, судалгаанд хамрагдсан өрхүүдийн нэг хүн сард дунджаар 4266,73 төгрөгийн цахилгааныг хэрэглэдэг байна.

⁴ Өрхүүдийн цахилгааны төлбөрт сард төлсөн мөнгөний хэмжээнээс хэрэглэсэн цахилгааны квтц-ийн хэмжээг тооцохдоо, айл өрхөд мөрдөгдөж буй энгийн тоолуурын 1кВтц цахилгааны 10% НӨАТ-тай тариф болох 87,78 төгрөгийг ашигласан.

Хүснэгт 4: Судалгаанд хамрагдсан өрхүүдийн хувийн жин, эрчим хүчний сарын хэрэглээний үзүүлэлтүүд, байршлаар

Өрхийн цахилгааны хэрэглээний үзүүлэлтүүд	Өрхийн байршил		Нийт
	Гэр хороолол	Байшин хороолол	
Өрхийн сарын цахилгааны хэрэглээ			
Цахилгаан хэрэглэдэггүй(холбогдоогүй)	1.5	0.0	0.7
Цахилгаан хэрэглэдэг	98.5	100.0	99.3
Үүнээс, 13167, буюу түүнээс бага (<150кВтц)	(49.7)	(22.9)	(36.3)
13168-21945(151-250кВтц)	(37.6)	(43.4)	(40.5)
21946, буюу түүнээс их(>251кВтц)	(11.2)	(33.7)	(22.5)
<i>Өрхүүдийн сарын дундаж цахилгааны зардал, төгрөгөөр</i>	<i>13,688.53</i>	<i>19,087.18</i>	<i>16,387.85</i>
<i>Өрхийн 1 х.н сарын дундаж цахилгааны зардал, төгрөгөөр</i>	<i>3513.30</i>	<i>5020.16</i>	<i>4266.73</i>
<i>Цахилгаан ашигладаг өрхүүдийн сарын дундаж цахилгааны зардал, төгрөгөөр</i>	<i>13,891.82</i>	<i>19,087.18</i>	<i>16,508.65</i>
Өрхийн сарын нийт орлогод цахилгааны зардлын эзлэх хувь			
Цахилгаан хэрэглэдэггүй	1.5	0.0	0.7
0.20-2.50%	31.7	36.5	34.1
2.51-5.00%	39.5	33.7	36.6
5.01%, түүнээс дээш	27.3	29.8	28.6
<i>Өрхүүдийн сарын нийт орлогод цахилгааны зардлын эзлэх дундаж хувь</i>	<i>4.6</i>	<i>4.1</i>	<i>4.3</i>
<i>Цахилгаан ашигладаг өрхүүдийн сарын нийт орлогод цахилгааны зардлын эзлэх хувь</i>	<i>4.7</i>	<i>4.1</i>	<i>4.4</i>
Бүгд	100.0	100.0	100.0
Судалгаанд хамрагдсан өрхийн тоо	205	205	410

Байршлын хувьд, гэр хорооллын өрхүүдийн цахилгааны сарын дундаж нийт хэрэглээ (13688,53 төгрөг) болон нэг хүнд ногдох хэрэглээ (3513,30 төгрөг) нь байшин хорооллын өрхүүдийн ижил үзүүлэлтүүдээс тус тус 5399 төгрөг болон 1507 төгрөгөөр бага байна.

Өрхүүдийн цахилгааны хэрэглээг *өрхийн орлогод цахилгааны зардлын эзлэх хувь* гэсэн хэмжүүрээр гаргаж үзвэл, өрхүүд сардаа дунджаар өрхийн нийт орлогын 4,3 хувьтай тэнцэх хэмжээний цахилгааныг хэрэглэдэг байна. Гэр хорооллын өрхүүдийн хувьд дунджаар сарын нийт орлогын 4,6 хувийг цахилгаанд зарцуулдаг байхад байшин хорооллын өрхүүд дунджаар сарын орлогын 4,1 хувийг цахилгаанд зарцуулдаг гэж гарлаа. Ойролцоогоор дээрх өрхүүдийн 30 орчим хувь нь сарын орлогынхоо 5-аас дээш хувийг цахилгаанд зарцуулдаг байна.

Нийслэлийн өрхүүдийн цахилгааны хэрэглээний дээрх үзүүлэлтийг бусад ижил төстэй хөгжлийн түвшинтэй улс орнуудынхтай жишиж үзэхийг оролдсон боловч харьцуулагдахуйц тоо мэдээлэл, судалгаа ховор байв. Харин 2010 онд Дэлхийн банкнаас хэвлэн гаргасан “Бага орлоготой өрхүүдийн эрчим хүчний зардал” сэдэвт судалгааны ажил⁵-д Ази, Африкийн

зарим хөгжиж буй орнуудын өрхүүдийн эрчим хүчний зардлыг харьцуулан судалжээ⁶. Уг судалгаагаар гаргасан өрхүүдийн эрчим хүчний зардлын мэдээллийг улс орных нь хөгжлийн ерөнхий түвшинг илэрхийлэх зарим үзүүлэлттэй хамт, мөн энэ удаагийн судалгааны үр дүнтэй харьцуулан Хүснэгт 5-д харуулав.

Эрчим хүчний талаарх статистикууд болон судалгаануудаас харахад орлого багатай, хотжилтын түвшин доогуур (хүн амын тал хүрэхгүй хувь нь хот, суурин газарт амьдардаг) орнуудад өрхүүд хоол ундаа болгох, халаалт зэрэгэрчим хүчний гол хэрэглээгээ био эх үүсвэрүүд (мод, ургамал, малын хоргол гэх мэт биологийн гаралтай сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрүүд)-ээс хангадаг ба бусад төрлийн эрчим хүчний хэрэглээгээ орчин үеийн эх үүсвэрүүд (газрын тосны гаралтай шатах материалууд, үйлдвэрлэгдсэн цахилгаан, байгалийн хий/газ)-ээс хангадаг байна.⁷

⁵ Robert Bacon, Soma Bhattacharya, and Masami Kojima, 2010. “Expenditure of low-income households on energy: Evidence from Africa and Asia”, *Extractive*

Industries for Development Series, #16, June 2010, (the World Bank, Oil, Gas, and Mining Policy Division Working Paper), USA: Washington.

⁶ Уг судалгаанд мэдээллийн эх үүсвэрийн хувьд харьцуулагдах боломжтой гэсэн шалгуураар нийт 9 улс орныг хамруулан судалсан ба үндсэн мэдээллийг нь улс тус бүрд хийгдсэн *Өрхийн орлого, зарлагын судалгаа*-нуудаас авсан байна.

⁷ Robert Bacon, Soma Bhattacharya, and Masami Kojima, 2010. “Expenditure of low-income households on energy: Evidence from Africa and Asia”, *Extractive Industries for Development Series*, #16, June 2010, (the World Bank, Oil, Gas, and Mining Policy Division Working Paper), USA: Washington.

Хүснэгт 5: Зарим улс орнуудын нэг хүнд ногдох үндэсний нийт орлого (ҮНО), хотжилт, өрхийн эрчим хүчний зардлын үзүүлэлтүүд

Сонгосон улсууд	Нэг хүнд ногдох ҮНО ¹ (PPP\$, 2008)	Хотын хүн амын хувь ¹ (2010)	Эрчим хүч ашигладаг хотын өрхүүдийн нийт зардалд эрчим хүчний орчин үеийн эх үүсвэр*-т төлсөн зардлын хувь ²	Түүвэр судалгаа хийгдсэн он
Уганда	1,140	13	2.9	2006
Кени	1,580	18	4.6	2006
Бангладеш	1,440	25	4.6	2005
Камбож	1,820	20	4.2	2004
Вьетнам	2,700	28	13.0	2006
Пакистан	2,700	35	8.5	2005
Энэтхэг	2,960	29	8.9	2004
Монгол	3,480	61	4.4**	2010
Индонези	3,830	44	8.4	2005
Тайланд	5,990	31	9.6	2006

Тэмдэглэгээ: *Орчин үеийн эрчим хүчний эх үүсвэртгазрын тос, цахилгаан, байгалийн хий орсон

** Монголын хувьд зөвхөн цахилгааны зардлыг тооцсон ба газрын тосны гаралтай шатах материал, байгалийн хийг эрчим хүчний эх үүсвэр болгон ашигладаг өрхүүдийн мэдээлэл байхгүй

Эх үүсвэр: PRB, World population data sheet 2010, Robert Bacon, Soma Bhattacharya, and Masami Kojima, 2010

Монголын хувьд орлогын түвшин доогуур ангилалд ордгоороо дээрх улс орнуудтай төстэй боловч хотжилтын түвшин харьцангуй өндөр байна. Нийслэл Улаанбаатарын гэр хороололд амьдардаг ихэнх өрхүүд хоол хүнсээ бэлтгэх, халаалт зэрэг эрчим хүчний хэрэглээндээ дээрх орнуудтай адил био эх үүсвэрийг хэрэглэдэг боловч эрчим хүчний орчин үеийн эх үүсвэр, тэр дундаа үйлдвэрлэгдсэн цахилгаан нийслэлийн өрхүүдийн дунд мөн өндөр хувьтайгаар хэрэглэгддэг. Ялангуяа байшин хорооллын өрхүүд бүгдээрээ, мөн гэр хорооллын өрхүүдийн зарим нь эрчим хүчний бүх төрлийн хэрэглээндээ голлон үйлдвэрлэгдсэн цахилгааныг хэрэглэдэг ба сүүлийн жилүүдээс л хоол хүнсээ болгохдоо гаазыг ашиглах хандлага бий болж байгаа. Гэхдээ манай судалгаанд гааз болон био эх үүсвэрээр эрчим хүч авч хэрэглэдэг өрхүүдийн тэдгээрт зарцуулдаг зардлын мэдээлэл байхгүй учраас зөвхөн үйлдвэрлэгдсэн цахилгаанд төлсөн мөнгөөр нь өрхийн эрчим хүчний орчин үеийн эх үүсвэрт зарцуулсан зардлыг хэмжсэн болохыг дурьдах нь зүйтэй.

Хүснэгт 5-д өгөгдсөн мэдээллээс харахад, орлого багатай, хотжилтын түвшин доогуур орнуудад өрхүүд нь орчин үеийн эх үүсвэрээс эрчим хүч хэрэглэх тохиолдолд түүний өртөг зардал нь өрхийн нийт хэрэглээний зардлын 2,9-13 хувийг эзэлж байгаа үр дүн гарсан байна. Энэ зардал судлагдсан 10 орлого багатай орнууд дотроосоо Уганда (2,9%), Камбож (4,2%), Монгол (4,4%) гэсэн орнуудад хамгийн бага, харин бусад 7 оронд арай өндөр буюу өрхийн нийт хэрэглээний зардлын 4,6-аас дээш хувийг эзэлж байна. Эрчим хүчний орчин үеийн эх үүсвэр хэрэглэдэг өрхүүдийн дунд эрчим хүчинд зарцуулах зардал Вьетнам (13%), Тайланд (9,6%), Энэтхэг (8,9%), Пакистан (8,5%), Индонези (8,4%) зэрэг орнуудад хамгийн өндөр буюу Монголоос 2-3 дахин өндөр байна.

Өрхүүдийн цахилгаанаар найдвартай хангагдаж буй байдлын нэг хэмжүүр нь цахилгааны тасалдал гарсан эсэх үзүүлэлт юм. Албан статистикуудаар цахилгаан хангамжийн тасалдлыг дараах

индексүүдээр хэмжиж тооцдог ба Монгол улсад эдгээрийг 2005 оноос эхлэн тооцож байна.⁸ Үүнд:

- Системийн цахилгаан тасалдлын дундаж хугацааны индекс (SAIDI-System average interruption duration index): Энэ нь жилд системийн хэмжээнд ногдож буй тасалдлын үргэлжлэх дундаж хугацааг харуулна (*минут/систем/жил*)
- Системийн цахилгаан тасалдлын дундаж тохиолдлын индекс (SAIFI-System average interruption frequency index): Энэ нь жилд системийн хэмжээнд ногдож буй тасалдлын давтамжийн тоог харуулна (*давтамж/систем/жил*)
- Хэрэглэгчийн цахилгаан тасалдлын дундаж хугацааны индекс (CAIDI-Customer average interruption duration index): Энэ нь жилд тасалдалд хамрагдсан 1 хэрэглэгчид ногдох тасалдлын үргэлжлэх дундаж хугацааг харуулна (*минут/хэрэглэгч/жил*)

Улаанбаатар хотыг хамруулан төвийн бүсийн хэрэглэгчдийн цахилгаан хангамжийн тасалдал сүүлийн 3 жилд ямар байсныг дээрх 3 индексээр илэрхийлэн Хүснэгт 6-д харуулав. Төвийн бүсийн хэмжээнд 2010 онд системийн дүнгээр нийт 3673 минут буюу 61 цагийн цахилгааны тасалдал 14 удаагийн тохиолдлоор гарсан нь өмнөх онуудынхаас буурсан үзүүлэлт байна. Тасалдалд хамрагдсан нэг хэрэглэгчид ногдох цахилгааны тасалдлын үргэлжилсэн хугацаа дунджаар 4,3 цаг гарсан байгаа нь мөн өмнөх 2 жилийнхээс буурсан үзүүлэлт байна. Эрчим хүчний зохицуулах газрын мэдээлж байгаагаар төвийн бүсийн хэмжээнд 2010 онд гарсан нийт цахилгааны тасалдлын 53 хувийг төлөвлөгөөт тасалдал, 26 хувийг түгээх компанийн шугам, тоноглолоос хамаарсан тасалдал, 9 хувийг байгалийн гамшгаас шалтгаалсан тасралт, 4 хувийг цахилгаан станцууд болон дамжуулах компанийн үйл ажиллагаанаас хамаарсан тасалдал, үлдсэн 8 хувийг бусад шалтгаан бүхий тасалдал бүрдүүлжээ.

⁸ ЭХЗГ 2010. Эрчим хүчний зохицуулах газрын 2009 оны үйл ажиллагааны тайлан, Улаанбаатар.

Хүснэгт 6: Төвийн бүсийн хэрэглэгчдийн цахилгааны тасалдлын индексүүд, 2008-2010

Цахилгаан тасалдлын индексүүд	Он		
	2008	2009	2010
Жилд системийн хэмжээнд гарсан тасалдлын дундаж хугацаа, минутаар (И _{саиди})	6015 (100 цаг)	12662 (211 цаг)	3673 (61 цаг)
Жилд системийн хэмжээнд гарсан тасалдлын давтамж, тоогоор (И _{саифи})	17	15	14
Жилд тасалдалд хамрагдсан нэг хэрэглэгчид ногдох тасалдлын дундаж хугацаа, минутаар (И _{канди})	344 (5.7 цаг)	836 (13.9 цаг)	257 (4.3 цаг)

Эх үүсвэр: ЭХЗГ 2010. Эрчим хүчний зохицуулах газрын 2009 оны үйл ажиллагааны тайлан, Улаанбаатар

Сүүлийн нэг жилийн хугацаанд тохиолдсон цахилгааны тасалдлын талаар судалгаанд хамрагдсан цахилгаанд холбогдсон нийт өрхүүдийн харьцангуй бага хувь (6,9%) нь сүүлийн 12 сарын хугацаанд өрхөд нь цахилгаан огт тасраагүй гэсэн байхад, 48,9 хувь нь цөөн хэдэн удаа, үлдсэн хувь нь нэлээд хэд, олон удаа, маш олон удаа цахилгаан тасалдсан мэдээллийг өгчээ. Байршлаар нь ялган харахад, Улаанбаатарын гэр хороололд цахилгааны тасалдал байшин хорооллынхоос их гардаг байна. Тухайлбал, гэр хорооллын өрхүүдийн дунд цахилгаан огт тасраагүй гэсэн мэдээллийг өгсөн өрхүүд (11,7%) байшин хорооллынхоос 5,8 дахин бага байхад цахилгаан маш олон удаа тасарсан гэсэн мэдээллийг өгсөн хувь (18,8%) байшин хорооллынхоос 4,8 дахин их байна. Сүүлийн 12 сард цахилгаан нь тасалдсан өрхүүдээс цахилгаан нэг тасрахдаа дунджаар хэр удаан үргэлжилснийг асуухад 58 хувь нь 1 цагаас удаан хугацаагаар, 18,8 хувь нь 31-60 минутаар, үлдсэн нь 30 хүртэл минутаар тасардаг гэсэн мэдээллийг өгчээ. Байршлын хувьд, цахилгаан удаан тасардаг гэсэн мэдээллийг гэр хорооллынхон (70%) байшин хорооллынхоос (45%) илүүтэй өгсөн байна. Судалгаанд хамрагдсан өрхүүдийн цахилгаан тасалдлын талаар өгсөн эдгээр мэдээллүүд нь ерөнхийдөө албан статистикийн мэдээлэлтэй нийцэж байна.

Эрчим хүчний салбарын талаарх өрхүүдийн мэдлэг, хандлага

Судалгаагаар олон нийтийн дунд Монголын эрчим хүчний салбарын талаарх мэдлэг хэр түгээмэл байгааг харах зарим

асуултууд оруулсан ба “Та цахилгаан эрчим хүч хаанаас ирдгийг мэдэх үү?”, “Цахилгааныг юунаас гаргаж авдгийг мэдэх үү?” гэсэн мэдлэг шалгах энгийн асуултуудыг асуусан юм.

Нийт хариулагчдын 68.5 хувь нь цахилгаан хаанаас ирдгийг, 58.3 хувь нь цахилгааныг ямар түүхий эдээс гаргаж авдгийг мэдэж байна. Гэхдээ эдгээрийн талаарх мэдлэг залуу насны, эмэгтэй хариулагчдын дунд ахимаг насны (35-аас дээш), эрэгтэй хариулагчдынхаас арай доогуур, боловсрол өндөртэй хүмүүсийн дунд боловсрол доогуур хүмүүсийнхээс илүү байв. Давхардсан тоогоор, цахилгаан хаанаас ирдгийг мэддэг хариулагчдын 96,1 хувь нь дотоодын эрчим хүчний компаниудаас, 14,6 хувь нь импортоор ирдэг гэдгийг мэдэж байв. Мөн цахилгааныг ямар түүхий эдээс гаргаж авдгийг мэддэг хариулагчдаар эрчим хүч гаргахад хэрэглэдэг анхдагч түүхий эдийг нэрлүүлэхэд давхардсан тоогоор 96,7 хувь нь нүүрсийг, 2,1 хувь нь газ/хийг, 3,8 хувь нь ус, дизель түлш болон сэргээгдэх нөөцүүд болох нар, салхи зэргийг нэрлэлээ. Эдгээрээс дүгнэхэд, эрчим хүчний талаарх ерөнхий, анхдагч мэдлэг олон нийтийн дунд боломжийн хэмжээнд (гуравны хоёр орчимд нь) байна.

Монгол улсын эдийн засаг зах зээлийн харилцаанд шилжээд 20 гаруй жил болж байгаа ч өнөөгийн байдлаар эрчим хүчний салбарт төрийн оролцоо өндөр хэвээр, зах зээлийн зарчмаар ажиллаж чадахгүй байгаа ба дотоодын эрчим хүчний ихэнх компаниуд олон шалтгаанаас үүдэн санхүүгийн хувьд үр ашиггүй, алдагдалтай ажиллаж, татаасаар амьдарч байгаа билээ.

Судалгаагаар, нийт өрхийн хариулагчдын дөнгөж 28,8 хувь нь Монголын эрчим хүчний компаниудыг эдийн засгийн хувьд үр ашиггүй, алдагдалтай ажилладаг гэдгийг мэдэж байгаа үр дүн гарлаа. Хариулагчдын 33,9 хувь нь уг салбарыг ашигтай ажилладаг гэж ойлгодог ба 37,3 хувь нь энэ талаар ойлголтгүй, мэдэхгүй гэсэн хариултыг өгсөн байна. Монголын эрчим хүчний компаниудын эдийн засгийн ерөнхий байдлын талаар огт мэдлэггүй байдал ахимаг насны, эмэгтэй, боловсрол доогуур, байшин хорооллын өрхүүдийн

хариулагчдын дунд бусад бүлгийнхнээс өндөр хувьтай байна.

Дотоодын эрчим хүчний компаниудыг алдагдалтай ажиллаж байгаа гэж хариулсан өрхийн хариулагчид (28,8 хувь)-аас уг компаниуд яагаад алдагдалтай ажиллаж байгаа талаарх ойлголт, үзэл бодлыг нь асуухад (Зураг 1), хамгийн олон давтагдсан шалтгаанд *эрчим хүч хэрэглэгчид хэрэглэсэн цахилгааны төлбөрөө хугацаанд нь төлдөггүй, зарим нь хулгайгаар хэрэглэдэг* (50%) гэсэн хариултыг нэрлэлээ.

Зураг 1: Судалгаанд хамрагдагсдын хувь, эрчим хүчний алдагдалтай ажиллаж буй шалтгааныг нэрлэсэн байдлаар



Тайлбар: Олон сонголттой хариулт тул нийлбэр дүн 100 хувиас илүү байна.

Үүнээс гадна зарим нь техникийн шалтгаануудыг, тухайлбал салбарын менежмент муу (39,4%), сүүлийн үед эрчим хүчний гол түүхий эд болох нүүрсний үнэ өсч, цахилгаан үйлдвэрлэх, түгээх зардлууд нэмэгдсэн (31,4%), цахилгаан станцуудын тоног төхөөрөмж хуучирч, заримынх нь ашиглалтын хугацаа дууссан (31,4%) зэргийг нэрэсэн боловч маш цөөхөн хэсэг (7,6%) цахилгааны нэгжийн үнэ үйлдвэрлэлийн зардлаас доогуур учраас алдагдалтай байгааг ойлгож байна.

Дээрх хариулагчдаас эрчим компаниудын эдийн засгийн үр ашиггүй байдлыг бууруулахын тулд ямар арга хэмжээ авах шаардлагатай талаар асуухад менежментийн шинэчлэл хийх (48,3%), салбарын бодлогын орчинг сайжруулах (33,1%) зэрэг хариултыг хамгийн олон хүн өгсөн байна. Мөн хэдийгээр нэг ч хүн тарифийг нэмэгдүүлэх хэрэгтэй гэж шууд хэлээгүй боловч 24,6 хувь нь салбарыг зах зээлийн системд шилжүүлэх, 20,3 хувь нь салбар руу хувийн хөрөнгө оруулалтуудыг татах, 5,1 хувь нь

хэрэглэгчдээс төлбөрөө гүйцэд авдаг болох, хэрэглэгчдийн хариуцлагыг нэмэгдүүлэх арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх хэрэгтэй гэж зөвлөсөн байна хэрэгтэй гэжээ.

Эдгээр мэдээллүүдээс дүгнэхэд, хэдийгээр эрчим хүчний салбарын өнөөгийн эдийн засгийн байдлын талаар зөв төсөөлөлтэй олон нийт цөөхөн байгаа ч тэдгээр цөөн хүмүүс салбарын нөхцөл байдлын шалтгаан, үндэс суурийг нэлээд бодьтойгоор ойлгож тайлбарлаж байгаа ба тэд салбарын шинэчлэлийг дэмжихэд чухал үүрэгтэй байх болно.

Судалгаагаар бид цахилгааны одоогийн мөрдөгдөж байгаа тарифын талаар хариулагчид ямар санал бодолтой явдгийг асуусан юм. Судалгаанд хамрагдсан нийт өрхийн хариулагчдын 64,9 хувь нь одоогийн мөрдөгдөж байгаа цахилгааны тарифийг өндөр, 34,4 хувь нь тохиромжтой буюу боломжийн, ердөө 0,7 хувь нь бага гэж үзэж байна. Тарифийг өндөр гэж үзэж байгаа хандлага нас, боловсрол, ажил эрхлэлт гэх мэт хариулагчдын хувь хүний шинж байдлаар онцын ялгаагүй (тодорхой зүй тогтол харагдахгүй) байна. Харин өрхийн шинж байдлаар авч үзвэл, тодорхой зүй тогтол бүхий ялгаанууд харагдлаа. Тухайлбал, цахилгааны тарифыг өндөр гэж үзэж байгаа хандлага гэр хорооллын, насанд хүрээгүй олон хүүхэдтэй, ядуу, сарын цахилгааны хэрэглээ нь өндөр өрхүүдийн дунд бусад бүлгийнхнээс илүүтэй байна.

Монгол Улсад 2002 оноос хойш цахилгааны үнэ тариф 2005, 2007, 2008, 2009, 2010 онуудад тус тус нэмэгдэн өөрчлөгдсөн ба сүүлийн хоёр жилийн үнэ тарифын өөрчлөлтийг өрхүүд хэрхэн анзаарсан байдлыг энэ судалгаагаар авч үзсэн. Судалгаанд хамрагдсан нийт өрхийн хариулагчдын 88,6 хувь нь сүүлийн 2 жилийн тарифийн өөрчлөлтийг өссөн гэж анзаарсан байхад 3,4 хувь нь хэвээр байсан, 8 хувь нь мэдэхгүй буюу өөрчлөлт анзаараагүй гэж хариулжээ. Тарифын өөрчлөлтийг анзаарсан байдал өндөр байгаа нь олон нийтийн дунд цахилгааны үнийн мэдрэмж өндөр байгааг, өөрөөр

хэлбэл тарифын ямар нэгэн өөрчлөлт хэрэглэгчдэд шууд анзаарагдахаар байгааг харуулж байна. Цахилгааны эрэлт нь бараг мэдрэмжгүй, өөрөөр хэлбэл үнэ өссөн ч хэрэглэгчдийн цахилгаан хэрэглэх хэмжээ онцын ихээр багасдаггүй учраас цахилгааны зардал өсөх тохиолдолд хэрэглэгчид тэрхүү нэмэгдсэн зардлыг зайлшгүй хэрэгцээнээс бусад бараа, үйлчилгээний хэрэглээ болон тансаг хэрэглээний зардлаа багасгах замаар нөхөх боломжтой.

Өнгөрсөн 2 жилд цахилгааны тариф өссөн гэж хариулагчдаас уг тарифийн өсөлтийн шалтгааныг хэрхэн ойлгосон талаарх бодлыг нь асуухад дотоодын цахилгаан станцуудын менежмент муу, алдагдалтай ажилладгаас (53,4%), мөн цахилгаан станцууд хуучирч, хүчин чадал хангалтгүй болсноос (31,4%) үнээ нэмсэн гэсэн салбарын дотоод үйл ажиллагаатай холбоотой шалтгаануудыг бусад хариултаас илүүтэй хэлэв. Үүний дараа импортын эрчим хүчний үнэ өссөн (23,4%), эрчим хүчний компаниудын тоо цөөн/хангалтгүй (16,3%), төрөөс эрчим хүчний үнийг тогтооход оролцдог (9,1%), эрчим хүчний түүхий эд болон үйлдвэрлэл, түгээлтийн зардлууд өссөн (8,5%) зэрэг гадны гэж болох хүчин зүйлстэй холбоотой шалтгаануудыг нэрлэлээ.

Сүүлийн 2 жилийн цахилгааны тарифийн өсөлтийг анзаарсан хариулагчдаас уг тарифийн өсөлт өрхийн амьжиргаанд нь хэр нөлөө үзүүлснийг асуухад, зөвхөн 9,8 хувь нь л амьжиргаанд онцын нөлөө үзүүлээгүй гэсэн хариултыг өгсөн ба 39,8 хувь нь бага зэрэг, 50,4 хувь нь нэлээд их/маш их нөлөөлсөн гэжээ (Хүснэгт 7).

Хүснэгт 7: Өнгөрсөн 2 жилд цахилгааны үнэ өссөн гэсэн өрхийн хариулагчдын хувийн жин, цахилгааны үнийн өсөлт өрхийн амьжиргаанд хэр их нөлөө үзүүлснийг мэдээлсэн байдал, нийгэм, эдийн засгийн шинж байдлаар

Хариулагчдын шинж байдал	Цахилгааны үнийн өсөлт өрхийн амьжиргаанд хэр нөлөө үзүүлсэн эсэх			Бүгд	Өрхийн хариулагчдын тоо
	Нөлөө үзүүлээгүй	Бага зэрэг	Нэлээд их		
Өрхийн байршил					
Гэр хороолол	11.7	38.3	50.0	100.0	188
Байшин хороолол	7.9	41.3	50.8	100.0	189
Өрхийн 0-15 насны хүүхдийн тоо					
0	12.8	35.2	52.0	100.0	125
1	12.2	44.3	43.5	100.0	131
2	4.7	42.9	52.4	100.0	84
3 буюу түүнээс олон	2.7	32.4	64.9	100.0	37
Өрхийн амьжиргаа					
Ядуу	4.9	31.5	63.6	100.0	162
Ядуу бус	13.5	46.0	40.5	100.0	215
Нийт	9.8	39.8	50.4	100.0	377

Өнгөрсөн хугацааны цахилгааны тарифын өсөлт өрхийн амьжиргаанд нь их нөлөө үзүүлсэн байдал өрхийн байршлаар онцын ялгаагүй байгаа боловч насанд хүрээгүй олон хүүхэдтэй (64,9 хувь), эсвэл ядуу өрхүүд (63,6 хувь) бусад өрхүүдээс илүүтэй цахилгааны тарифийн өсөлтийг хүндээр хүлээн авсан байна.

Цахилгааны тарифын ойрын ирээдүйн чиг хандлагыг албан байдлаар УИХ 2010 оны 12-р сарын 09-нд баталсан “Түлш, эрчим хүчний салбарын талаар авах зарим арга хэмжээний тухай тогтоол”-оороо тодорхойлон гаргаад байна. Уг тогтоолын 1.7 заалтад тусгагдсанаар, улсын төсвөөс салбарт татаас олгох хугацаанд буюу 2014 он хүртэл ахуйн цахилгааны хэрэглээний үнэ, тарифыг шатлалтай болгон өрх бүрийн сарын 150кВтц-ийг одоогийн мөрдөж байгаа үнэ тарифыг индексжүүлэн тооцож, түүнээс дээшхи хэрэглээг болон аж ахуйн нэгжийн эрчим хүчний үнэ тарифыг бодит өртгөөр тооцохоор төлөвлөж байгаа ба 2014 оноос эхлэн эрчим хүчний салбарын компаниудыг зах зээлийн зарчимд шилжүүлэн ажиллуулах төлөвтэй байна. Энэхүү тогтоол нь цахилгааны тариф татаасгүй бодит өртгөөр буюу одоогийнхоос өндөр үнээр хэрэглэгчдэд хүрэх нөхцөл ойрын ирээдүйд бий болохыг баталгаажуулж байна.

Олон нийт цахилгааны ирээдүйн үнэ тарифын талаар ямар бодолтой байгааг тодруулах үүднээс энэ судалгаагаар,

өрхүүдээс ойрын ирээдүй болон дунд хугацаанд цахилгааны үнэ тариф хэрхэн өөрчлөгдөнө гэж төсөөлж байгаа, түүний шалтгааныг юу гэж бодож буй талаар мэдээлэл цуглуулсан. Судалгаагаар, өрхүүдийн гуравны нэг буюу 63,9 хувь нь ойрын ирээдүй болон дунд хугацаанд цахилгааны тариф өснө гэсэн төсөөлөлтэй байгаа ба 10,5 хувь нь одоогийн түвшинд байна, 7,1 хувь нь буурна гэсэн төсөөлөлтэй, харин 18,5 хувь нь тодорхой төсөөлөл байхгүй буюу мэдэхгүй гэсэн хариултыг өглөө.

Ойрын ирээдүйд цахилгааны үнэ өснө гэж бодож буй хариулагчдаас үнэ өсөх шалтгааныг асуухад талаас илүү буюу 58,4 хувь нь өргөн хэрэглээний бараа үйлчилгээний үнийн өсөлт, цалингийн өсөлт, бэлэн мөнгө ихээр тарааж байгаа, эрчим хүчний түүхий эдийн үнийн өсөлт, үйлдвэрлэл, түгээлтийн зардлын өсөлттэй холбоотойгоор дагалдан цахилгааны үнэ өснө гэж төсөөлж байгаа нь бусад төрлийн хариулт өгөгчдөөс өндөр хувь эзэлж байв. Үүний дараа, эрчим хүчний салбарын үндсэн бэрхшээлтэй асуудлуудаас болж цахилгааны тариф өснө гэж ойлгож буй хариулагчид орж байна. Тухайлбал, хариулагчдын 23,7 хувь нь эрчим хүчний компаниуд өр авлага ихтэй, алдагдалтай ажилладаг/салбарын үйл ажиллагаа нь хэвийн бус, хүчин чадал муу учраас, 11,5 хувь нь цахилгаан хэрэглэгчдийн тоо эрчимтэй нэмэгдэж байхад эрчим хүч

үйлдвэрлэгч компаний тоо цөөн/хангалтгүй учраас цахилгааны тариф өснө гэж төсөөлж байгаа аж.

Ойрын ирээдүй болон дунд хугацаанд цахилгааны үнэ хэвээр байна, эсвэл буурна гэж үзэж буй хариулагчдаас яагаад цахилгааны үнэ өсөхгүй гэж бодож байгаа шалтгааныг асуухад нийгмийн сайн сайхны төлөө үнэ нэмэхгүй, өөрөөр хэлбэл үнэ нэмбэл хэрэглэгчид төлөх чадваргүй, агаарын бохирдол их байгаа тул цахилгааны үнийг багасгаж утааг бууруулах байх, тариф саяхан нэмэгдсэн болохоор дахиж нэмэхгүй байх гэсэн хариулт (34,7%) бусад хариултаас өндөр хувь эзэлж байна. Үүнээс гадна, шинэ цахилгаан станц баригдаж, эрчим хүчний нийлүүлэлт өсөх тул (20,8%), төрөөс эрчим хүчний салбарт шинэчлэл зохицуулалт хийж үнийг тогтворжуулах учраас (13,9%), эдийн засаг өсч, юмны үнэ тогтворжиж байгаа тул (8,3%) цахилгааны үнэ ойрын болон дунд ирээдүйд өсөхгүй байх гэсэн хариултуудыг зарим хүмүүс өглөө.

Эрчим хүчний салбарт хийгдэж буй шинэчлэлийн дагуу салбар 2014 оноос зах зээлийн зарчмаар ажиллаж эхлэхээр албан ёсны баримт бичигт заагдаад байгаа ба энэ үед цахилгаан үйлдвэрлэлээс хэрэглэгчдэд хүрэх бүхий л шатны өртөг зардлыг тусгасан бодит өртгөөр хэрэглэгчдэд хүрнэ. Энэ нь мэдээж одоогийн мөрдөгдөж буй төрийн татаасыг тусгасан доогуур үнээс өндөр байх магадлалтай юм. Тэгвэл санхүү, эдийн засгийн чадавхийг нь дээшлүүлж, салбарыг хөл дээр нь босгоход чухал үүрэгтэй дээрх үнэ тарифын өсөлтөд өрхүүд хэр бэлэн байгаа талаар бид судалгаагаараа асуусан юм.

Судалгааны “Цахилгааны тасалдал гаргахгүй, эрчим хүчний компаниудыг үр ашигтай ажилладаг болгохын тулд танай өрх одоогийнхоос илүү тарифаар цахилгааны төлбөр төлж чадах уу?” гэсэн асуултад нийт өрхүүдийн 30,5 хувь нь л итгэлтэйгээр “тийм” гэж хариулсан ба 45,4 хувь нь “үгүй”, 24,1 хувь нь “сайн мэдэхгүй/итгэлгүй байна” гэсэн хариултыг өгчээ. Цахилгааны төлбөрийг нэмэгдсэн тарифаар төлөхөд бэлэн биш байгаа хариулагчид ахимаг насны, боловсрол доогуур, ажил эрхлээгүй, байшин хорооллын, насанд хүрээгүй олон хүүхэдтэй, ядуу, сарын цахилгааны хэрэглээ нь бага өрхүүдийн дунд бусад өрхүүдийнхээс өндөр байна. Нэмэгдсэн

тарифаар цахилгааны төлбөр төлж дийлэх эсэхдээ итгэлгүй байгаа хариулагчид бусад хариулагчдыг бодвол 18-35 насны, тусгай дунд буюу дээд боловсролтой, ажил эрхэлдэг, байшин хороололд амьдардаг, олон хүүхэдтэй, ядуу, сардаа дундаж буюу 151-250 кВтц цахилгаан хэрэглэдэг айл өрхүүдийн дунд элбэг байна. Эндээс, цахилгааны тарифын өсөлтийг нийгмийн эмзэг төдийгүй, дундаж давхаргын айл өрхүүд ч нэлээд эмзэгээр хүлээн авч болзошгүй нь харагдлаа.

Нэмэгдсэн тарифаар цахилгааны мөнгө төлөхийг зөвшөөрөх эсэх нь ядуу өрхүүдийн хувьд төлөх чадварын асуудлыг хөндөж байна. Эрчим хүчний эрэлт нь мэдрэмж муутай, өөрөөр хэлбэл тариф өссөн ч эрчим хүчний хэрэглээний хэмжээ ихээр буурдаггүй учраас цахилгааны үнэ нэмэгдсэн тохиолдолд цахилгааны хэрэглээгээ хэвээр байлгана гэвэл нэн ядуу өрхүүдийн хувьд хоол хүнс, эрүүл мэнд, боловсрол гэх мэт зайлшгүй хэрэглээнүүдэд нь дарамт учрах болно. Иймд, нэн ядуу өрхүүд өөр сонголтгүйгээр тог хэрэглэхээ больж болох юм. Орлого өндөр өрхүүдийн хувьд одоогийнхоос илүү тарифаар цахилгааны төлбөр төлөхийг зөвшөөрөх эсэх нь цахилгаан юмуу зайлшгүй хэрэгцээнээс бусад гар утас, автомашин гэх мэт зүйлд зарцуулах зардлын хооронд сонголт хийх асуудлыг хөндөж болзошгүй.

Эрчим хүчний салбарын талаарх өрхүүдийн мэдээлэл авсан байдал, мэдээллийн хэрэгцээ

Эрчим хүчний салбарын талаар мэдээлэл авч байсан эсэхийг асуухад, өрхөөс судалгаанд хамрагдсан нийт хариулагчдын 80 хувь буюу 328 нь эрчим хүчний салбарын талаар тодорхой мэдээлэл авч байсан хүмүүс байв. Тэдний уг мэдээллээ ямар эх үүсвэрүүдээс авч байсныг сонирхвол давхардсан тоогоор 88,1 хувь нь телевизийн нэвтрүүлгүүдээс, 16,2 хувь нь сониноос, 15,9 хувь нь эрчим хүчний салбарын ажилтнуудаас, 13,1 хувь нь радио/ FM нэвтрүүлгүүдээс, 4,3 хувь нь интернэтээс, 2,1 хувь нь ухуулга сурталчилгааны жижиг материалуудаас, 1,8 хувь нь хүмүүсийн яриа, зарлал гэх мэт бусад эх үүсвэрүүдээс авч байсан гэжээ.

Эрчим хүчний салбарын талаар урьд нь

мэдээлэл авч байсан гэсэн өрхүүдийн 24,1 хувь нь сүүлийн үед тодорхой мэдээлэл аваагүй байгаа ба бусад хариулагчдын хувьд сүүлийн үед хамгийн их мэдээлэл авсан сэдэв нь эрчим хүчний үнэ тарифын асуудал (54,9%) байв. Үүнээс гадна давхардсан тоогоор, хариулагчдын 18,3 хувь нь эрчим хүчний салбарын өнөөгийн байдлын талаар, 7,3 хувь нь эрчим хүчний хангамжийн талаар, 7,3 хувь нь эрчим хүчний хэрэглээний талаар, 6,7 хувь нь эрчим хүчний бодлогын талаар, 3,7 хувь нь салбарын найдвартай үйл ажиллагааны талаар, 3,3 хувь нь шинэ баригдах цахилгаан станцын талаар, 1,2 хувь нь эрчим хүчний хувьчлал, үнийг чөлөөлөх тухай мэдээллүүдийг сүүлийн үед авсан гэжээ. Дээрхээс дүгнэхэд, эрчим хүчний салбарт сүүлийн үед болж буй үйл явдлуудын мэдээллүүд дотроос үнэ тарифтай холбоотой мэдээлэл олон нийтийн анхаарлыг хамгийн их татсан байна.

Өрхүүдээс Монголын эрчим хүчний салбарын талаар цаашид мэдээлэл авах хэрэгцээ байгаа эсэхийг асуухад, бараг бүгд буюу 94,4 хувь (387 хариулагч) нь “тийм” гэж хариуллаа. Цаашид эрчим хүчний салбарын талаар мэдээлэл авах хэрэгцээтэй гэсэн хариулагчдаас ямар сэдвээр мэдээлэл авах хүсэлтэй байгааг асуухад, салбарын өнөөгийн байдлын тухай (53%), эрчим хүчний үнэ тарифын тухай мэдээлэл (40,8%)-үүд хамгийн эрэлт хэрэгцээтэй гэсэн үр дүн гарлаа. Эрчим хүчний үнэ тарифын талаарх мэдээллийн хүрээнд өрхүүд цахилгааны нэгжийн үнийг хэрхэн тогтоодог, өнгөрсөн одоо, ирээдүйн үнэ тариф хэд болох, тэдгээрийн шалтгаан, нэгж квтц цахилгааны тариф айл өрх, байгууллагуудад ямар ялгаатай байдаг, цахилгаан хэрэглээний өдөр шөнийн буюу цагийн ялгавартай үнэ тариф хэд болох гэх мэт мэдээллүүдийг сонирхож байна.

Эдгээрээс гадна өрхүүдийн 9,1 хувь нь цахилгааны төлбөр тооцоог хэрхэн бичдэг (тоолуурын бичилт), төлбөр хураадаг механизм, гэрлийн байцаагчдын эрх, үүрэг, ёс зүй ямар байдаг талаар, 9 хувь нь Монголд ажиллаж буй цахилгаан станцуудын гаргадаг бүтээгдэхүүний хэмжээ, орлого, зарлага, тэдгээрийн хуваарилалт, ашиг, алдагдлын байдлын талаар, 5,7 хувь нь салбарын хүчин чадал, техник технологи,

хөрөнгө оруулалтууд болон шинээр баригдах цахилгаан станцын ерөнхий танилцуулга төлөвлөгөөний тухай, 5,7 хувь цахилгааныг хаана хэрхэн үйлдвэрлэж, хэрэглэгчдэд хүргэдэг, тогны тасалдал гарах болон тогны хүчдэл бага ирдэг шалтгааны талаар мэдээлэл авахыг хүсч байна.

Судалгаагаар, эрчим хүчний холбогдолтой бодлого, хууль дүрэм, салбар дахь төрийн оролцоо, салбарт хийгдэж байгаа болон хийгдэх гэж буй өөрчлөлт, шинэчлэлүүдийн тухай хариулагчдын 5,1 хувь нь мэдээлэл авах хүсэлтэй гэж гарлаа. Эрчим хүчний салбарт хийгдэх шинэчлэлүүдийн үр дүнд өрхийн эдийн засагт тулгарч болзошгүй хүндрэлүүдийг бууруулах, ачааллаа хөнгөлөх үүднээс зарим өрхүүд (5,4%) цахилгааны үнийг бууруулах эсвэл нэмэхгүй байх боломж байгаа эсэх, мөн салбарын урамшуулал хөнгөлөлт, шинээр гарч байгаа/ гарах хэрэглэгчдэд ээлтэй үйлчилгээнүүд юу байдгийг мэдэхийг хүсч байна. Хэрэглэгчдэд ээлтэй үйлчилгээг нэвтрүүлэх хүрээнд, өрхүүд хэрэглээндээ тохируулсан урьдчилсан төлбөрт тоолуур хэрэглэх боломж, мөн цахилгааны тарифыг өрхийн амьжиргаагаар ялгавартай тогтоох боломж байгаа эсэхийг онцлон сонирхож байв. Үүнээс гадна хэрхэн цахилгааныг хэмнэх, тогны хэрэглээгээ хянах, ахуйн хэрэглээний зүйлс хэр их тог иддэг талаар энгийн зөвлөгөө өгсөн мэдээлэл хэрэгтэй байна гэж хариулагчдын 3,4 хувь хэлснээс харахад цахилгааныг хэмнэх сонирхол олон нийтийн дунд тодорхой хэмжээгээр байна.

Гэр хорооллын өрхүүдээс ярилцлага авах үед байшин хорооллын өрхүүдийн хөндөөгүй онцлог нэг санал гарсан нь өнөөг хүртэл гэр хорооллын цахилгаанд холбогдсон айлууд бүрэн хэмжээгээр тусдаа тоолууртай болж чадаагүй, хэдэн айлын дунд нэг тоолууртай, түүний заалтыг тогны байцаагч өөрийн үзэмжээр айлуудад хуваан төлбөр ногдуулдаг, мөн тоолуурыг гэр хороололд өндөр шонд байрлуулсан байдгаас энгийн өрхүүд хүссэн үедээ тоолуураа хянах боломжгүй байдаг тухай асуудал байв. Үүнтэй холбоотойгоор хариулагчдын 2 хувь нь гэр хороололд тогны шийдийг хангалттай болгох боломж байгаа эсэх, мөн захын гэр хорооллуудад цахилгааны хангамжийг нэмэгдүүлэх, тоггүй айлуудыг

тогтой болгох боломж юу байгааг судлан мэдээлэл өгөхийг хүслээ.

ДҮГНЭЛТ

Салбарын талаарх олон нийтийн мэдлэгийг авч үзвэл, цахилгаан эрчим хүчийг хаана, ямар түүхий эдээр үйлдвэрлэж, хэрэглэгчдэд нийлүүлдэг талаарх ерөнхий мэдлэг боломжийн өндөр түвшинд байгаа боловч салбарын өнөөгийн санхүүгийн байдал хүнд байгааг мэдэж буй олон нийт харьцангуй цөөн байна. Энэ нөхцөл байдлыг мэдэж байгаа хүмүүсийн дунд маш цөөхөн хэсэг нь цахилгааны үнэ хэт доогуур тогтоогдсоноос салбар алдагдалтай ажиллаж байгаа гэж хэлсэн ба асуудлыг шийдэхийн тулд үнэ, тарифийг нь өсгөх хэрэгтэй гэж илэрхий хариулсан хариулагч нэг ч гарсангүй. Гэхдээ, өрхүүдийн 24,6 хувь, ААНБ-уудын 9,1 хувь нь зах зээлийн системийг салбарт хэрэгжүүлэх замаар асуудлыг шийдвэрлэх хэрэгтэй гэж зөвлөсөн нь шууд бус утгаараа урт хугацааны ахиу зардал дээр үндэслэн үнэ тогтоох тухай санаа байж болох юм.

Эрчим хүчний үнэ тарифын асуудалд олон нийт хэрхэн ханддагийг харвал, одоогийн мөрдөгдөж буй тарифыг өндөр

гэж гуравны хоёр нь үзэж байгаа ба сүүлийн 2 жилийн тарифын өсөлтийг дийлэнх нь анзаарсан байна. Сүүлийн 2 жилийн тарифын өсөлтийг анзаарсан хүмүүсийн олонх нь тарифын өсөлтийн шалтгааныг эрчим хүчний компаниудын дотоод хүчин зүйлс (дотоодын цахилгаан станцуудын менежмент муу, цахилгаан станцууд хуучирсан, хүчин чадал хангалтгүй гэх мэт)-тэй холбон ойлгож байгаа ба өрхүүдийн 50,4 хувь нь цахилгааны үнийн өсөлт өрхийн амьжиргаанд нэлээд их/маш их нөлөө үзүүлсэн гэж үзэж байна.

Ойрын болон дунд ирээдүйд цахилгааны үнэ өснө гэсэн төсөөлөлтэй хариулагчид өрхүүдийн дунд 63,9 хувь байгаагаас харвал салбарт хийгдэх үнэ тарифын шинэчлэлийн зайлшгүй байдлыг өрхүүдийн дийлэнх мэдэж байна. Гэвч, үнэ тарифын шинэчлэлийн үр дүнд гарч болзошгүй нэмэлт эдийн засгийн ачааллыг даахад олон нийтийн дийлэнх бэлэн бус байна. Ялангуяа, ядуу, олон хүүхэдтэй, цахилгааны хэрэглээ багатай айлууд нэмэгдсэн тарифаар цахилгааны төлбөр төлж чадах эсэхдээ илүү итгэлгүй байгаа нь анхаарал татаж байна. Эдгээр бүлгийнхэн нь салбарт шинэчлэл хийж, үнийг нэмэх үед бодлогын түвшинд анхаарлын төвд байх гол бүлэг мөн.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

Carl Haub and Population Reference Bureau 2010. *2010 World population data sheet*, USA: Washington (available at: http://www.prb.org/pdf10/10wpds_eng.pdf)

Жон Шварцбау, С.Амарсанаа 2002. *Эрчим хүчний салбарын шинэчлэлийг дэмжиж, олон нийтийн боловсролыг дээшлүүлэх хөтөлбөр*, Улаанбаатар.

International Energy Agency 2010. *Key world energy statistics 2010*, France:Paris (available at: <http://www.iea.org/about/copyright.asp>)

Robert Bacon, Soma Bhattacharya, Masami Kojima, 2010. "Expenditure of low-income households on energy: Evidence from Affrica and Asia", *Extractive Industries for Development Series*, #16, June 2010, (the World Bank, Oil, Gas, and Mining Policy Division Working Paper), USA: Washington.

УИХ. 2001. *МУ-ын эрчим хүчний тухай хууль*. Монгол Улсын Их Хурал.

УИХ. 2010. "Түлш, эрчим хүчний салбарын талаар авах зарим арга хэмжээний тухай тогтоол", УИХ-ын 2010 оны 12-р сарын 09-ний тогтоол.

ҮСХ 2010. МУ-ын статистикийн эмхтгэл 2009, Монгол Улсын Үндэсний Статистикийн Хороо, Улаанбаатар.

ЭХЗГ. 2008. *Төвийн бүсийн эмзэг бүлгийн тарифыг мөрдөх журам*, ЭХЗГ-ын Зохицуулагчдын зөвлөлийн 2008 оны 11 сарын 11-ний 176 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралт.

ЭХЗГ 2010. Эрчим хүчний зохицуулах газрын 2009 оны үйл ажиллагааны тайлан, Улаанбаатар.

<http://www.era.energy.mn>

<http://www.mmre.energy.mn/branch/history>

<http://www.nso.mn/v3/index.php?page=abdt&id=15>

<http://www.era.energy.mn/index.php?com=content&id=19>